

“ЧАНДМАНЬ УУЛЫН ХИШИГ” ХХК

**БАЙГАЛ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ  
2022 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ**

Улаангом  
2022 он

**ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ**  
**Уурхайн ерөнхий мэдээлэл**



<b>Төслийн нэр</b>	Арсайн хөндийн элс хайрганы холимогийн ордыг ил аргаар ашиглах
<b>Төсөл хэрэгжүүлэгч</b>	“Чандмань Уулын Хишиг” ХХК
<b>Хаяг, байршил:</b>	Увс аймаг, Улаангом сум, 2-р баг
<b>Төсөл хэрэгжиж эхэлсэн хугацаа</b>	2019 оноос
<b>Утас:</b>	Утас: 88152006, <a href="mailto:m.ulaankhuu@yahoo.com">m.ulaankhuu@yahoo.com</a>
<b>Газар ашиглах зориулалт</b>	Шаврын ордыг ашиглах зорилгоор газар эзэмшиж байна.
<b>Ашиглах талбай:</b>	26.09 га газар
<b>Төслийн байршил:</b>	Увс аймгийн Улаангом сумын газар нутаг
<b>Регистрийн дугаар</b>	4019598
<b>Гэрчилгээний Дугаар</b>	1511010055
<b>Ашиглалтын лиценз</b>	XV-85000012-002-NM
<b>Хүчин чадал</b>	Арсайн хөндийн элс-хайрганы холимгийн ордоос жилдээ 25.0 мян.м3 элсхайрга олборлох хүчин чадал бүхий ил уурхайг ажиллуулахаар төлөвлөв. Нийт үйлдвэрлэлийн нөөц 217.26 мян.м3 байна. Төслийн хүчин чадал зах зээлийн эрэлт нийлүүлэлтээс хамаарч байна.
<b>Хүний нөөц</b>	18 ажилтантай
<b>Техникийн хүчин чадал</b>	Утгуурт ачигч-1, Хово-3, экскаватор-1, ачигч трактор-1, элс хайрга шигшин ангилагч-2, угаах төхөөрөж-2, хацар бутлагч-1, эсрэг цохилтод бутлагч-1 ширхэг
<b>Ажиллах хугацаа</b>	Арсайн хөндийн элс-хайрганы холимгийн ордын хувьд ил уурхайн хүчин чадал $T=217.26 \text{ мян.м}^3 / 25.0 \text{ мян.м}^3 = 8.7 \approx 9$ жил байна.
<b>Ил уурхайн ажиллах горим</b>	Уурхайн ажиллах горимыг уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээ, хэрэглэгчдийн хэрэглээний хугацаанаас хамааруулан жилд 04 сараас 09 сарын 15-г дуустал буюу 5 сарын хугацаанд ил уурхай өдөрт 8 цагийн 1 ээлжээр ажиллана. Уурхайн жилд ажиллах хоног 168 хоног ажиллах горимтой.
<b>Ордын нөөц</b>	Арсайн хөндийн элс-хайрганы холимгийн ордын В зэрэглэлээр бодогдсон нөөц нь 205.1 мян.м3 , боломжтой С зэрэглэлээр 483.8 мян.м3 , нийт 688.9 мян.м3 элс-хайрганы нөөц тооцогдсон.

## Уурхайн байршил


Улаангом сумын нутагт Улаангом хотоос урагш 6-7 км зайд Улаангом-Ховд хотыг холбосон сайжруулсан авто замын дагуу байрлаж байна.

Хүснэгт 1. Талбайн солбилцол

№	Уртраг	Өргөрөг
1	49° 55' 27.44"N	92° 02' 42.5" E
2	49°54'20.69"N	92° 2'29.61"E
3	49°54'20.16"N	92° 3'1.29"E
4	49°53'57.94"N	92° 2'56.59"E



### Уурхайн дамжлагын бүдүүвч



## 2023 ОНД БОРЛУУЛАЛТ ХИЙСЭН ХАЙРГА, БЕТОН ЗУУРМАГИЙН ДҮН /2022/10/15-ны байдлаар/


Үйлдвэрийн засварын ажил 2022 оны 03 дугаар сарын 17-нд эхэлж, туузан дамжуурга, бутлуур, шигшүүр, хайрга угаах дамжлага, бетон зуурмагийн туузан дамжуурга, бункер, зуурагчийн тоног төхөөрөмж зэрэгт урсгал засварын ажлуудийг хийж, тоног төхөөрөмжийн ажиллагааг хэсэгчилэн болон бүхлээр нь шалган жигдэрүүлж, хайрга болон бетон зуурмагийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа 04 дүгээр сарын 20-оос ажилласан. 2022 оны хийх ажлын төлөвлөгөөний дагуу ажиллаж, хайрга-1670 м3, бетон зуурмаг 4486м3 үйлдвэрлэсэн бөгөөд задаргааг дараах хүснэгтэд харуулав

д/д	Хайрга болон бетон зуурмагийн нэр	Нийт хэмжээ м3	Тайлбар
<b>Хайрга</b>			
1	10-20 мм-ын шигшсэн хайрга	629 м3	
2	5-10 мм-ын шигшсэн хайрга	767 м3	
3	0,5 мм-ын угаасан хайрга	274 м3	
Нийт дүн		<b>1670 м3</b>	
<b>Бетон зуурмаг</b>			
1	M100 марк	27 м3	
2	M150 марк	434 м3	
3	M200 марк	174 м3	
4	M250 марк	2986 м3	
5	M300 марк	183 м3	
6	M350 марк	682 м3	
Нийт дүн		<b>4486 м3</b>	

2023 онд техник, механизмдын дутагдалтай болон давуу талуудыг үндэслэн хуучин ашиглаж байсан эксковатр, хово маркын техникийг шинэчлэн ковш 2 нэгж худалдан авч үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа ашиглахаар төлөвлөн ажиллаж байна. Өөрөө ачиж буулгах зориулалт бүхий ковш нь ажлын бүтээмж өндөр, эдэлгээ сайн, үйлдвэрийн ажиллах горимд бүрэн нийцэхээр байгаа зэрэг сайн талуудтай.

## 2022 ОНД ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ БОЛОН АРИЛГАХ, ТОХИЖИЛТ, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Эрсдэл өндөртэй байдлын эрсдэлийг бууруулах, арилгах, ажилчдын ахуй хангамжийг сайжруулах, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэлийн хангамж, байгаль орчин нөлөөлөх нөлөөллийг багасгах, арилгах, галын аюулгүй байдлыг хангах, галыг унтраахад шаардагдах багаж хэрэгсэл, түүний иж бүрдэл, нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэх ажлуудад анхаарч ажилласан бөгөөд дараах хүснэгтэд хийсэн ажлыг нэг бүрээр нь тайлбар зургийн хамт оруулав.

Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний хамрах хүрээ	Хэмжих нэгж, мян.төг	Биелэлтийн шалгуур	Биелэлт
Хөрсөн бүрхэвч				
Үйлдвэрийн орчны зам талбайг хатуу хучилттай болгох (хөрсийг хуулан 3-5 см зузаан шавар үеийг нягтаршуулан болзошгүй тохиолдлоор бензин, тос гоожих, асгарах нөхцөлд доош хөрсөнд нэвчихээс хамгаалсан хаалт (екран) хийн дээрээс нь цардсан (цементэн) хучлага хийж өгөх)	Үйлдвэрийн хашаанд	3,750,0	Ажлын явцийг зургаар баталгаажуулах	<p>- Үйлдвэрийн талбай бүрэн хатуу болгоогүй боловч хог хаягдлын битүү савыг байршуулсан. Түүхий эд буюу хог хаягдлыг хашаанд нөөцлөхөө больсон.</p> <p>- Машин механизмд засвар үйлчилгээ хийхэд зориулан хөрснөөсөө тусгаарлагч бүхий цементэн талбайтай болсон</p> 






<p>Хог хаягдлыг тусгайлан бэлтгэсэн зориулалтын талбайд хаяагүйгээс хөрсөн бүрхэвч бохирдох, хог хаягдал дээр хорхой шавьж, шувуу цугласнаар элдэв өвчин тархах учир урьдчилан сэргийлж зориулалтын саванд түр хадгалж, тогтмол зайлуулж байх</p>	<p>Үйлдвэрийн хашаанд</p>	<p>10 тн хог хаягдал</p>	<p>Байршуулсан байх, гэрээ байгуулсан байх</p>	<p>Улаангом сумын тохижилт, үйлчилгээний газартай гэ байгуулан тогтмол ахуйн хог хаягдлыг зайлуулдаг.</p>
<p><b>Агаарын чанарт нөлөөлөх</b></p>				
<p>Тээврийн хэрэгслийн үйлчилгээ оношлогоог тогтмол хийх, агаар бохирдуулсаны төлбөр төлөх</p>	<p>Бүх тээврийн хэрэгсэл</p>	<p>200.0</p>	<p>4 тээврийн хэрэгсэл</p>	<p>Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогоод орсон, өөрийн засварын төвд үйлчилгээг тогтмол хийдэг.</p>
<p>Халааж бутлах, хэвлэх явцад хорт утаа агаар орчныг бохирдуулдаг.</p>	<p>Үйлдвэр</p>	<p>4</p>	<p>Хэвийн ажиллагаатай</p>	<p>Агааржуулалтын тоог нэмсэн ба агааржуулагч дээр цэвэршүүлэгч, шүүр байршуулсан.</p>
<p>Үйлдвэрийн ажиллагаанаас шалтгаалсан тоосжилт</p>	<p>Үйлдвэр</p>	<p>1</p>	<p>Зургаар баталгаажуулах</p>	<p>Үйлдвэрийн ажиллагаанаас шалтгаалсан тоосжилтыг дарах зорилгоор өдөр бүр 2 удаа үйлдвэрийн талбайг усаар шүршиж норгодог.</p> 

**Ажилчдын эрүүл мэнд**




<p>Эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэх</p>	<p>Нийт ажилчдад</p>	<p>0</p>	<p>MNS 6458:2014</p>	<p>Ажил дээр усанд орох, хувцас солих өрөө зэргийг тохижуулсан</p>	
<p>Хамгаалах хувцас хэрэгсэл олгох</p>	<p>Нийт ажилчдад</p>	<p>0</p>	<p>Ажлын хувцас олгох, хураан авах, актлах журам гаргаж батлуулсан байх</p>	<p>Ажлын хувцас олгох, хураан авах, актлах журам гаргаж батлуулсан, өвөл зуны ажлын хувцастай болгосон.</p>	
<p>Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж зохион байгуулах ажил</p>	<p>Нийт ажилчдад</p>	<p>0</p>	<p>ХАБЭА тухай хууль</p>	<p>Шороо, тоосноос хамгаалах хушуувч, амны маск, чимээнээс хамгаалсан чихэвч, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангадаг.</p>	



<p>Тоног төхөөрөмжтэй ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгөх</p>	<p>Бүх ажилчид</p>	<p>Нийт 25 ажилтан</p>	<p>Жил бүр</p>	<p>Зааварчилгаа өгөх, тогтмол хяналт тавих, ХАБЭА-н ажилтан томилон ажиллуулдаг. ХАБ-н мэдээллийн самбарт мэдээллийг байршуулсан, ХАБЭА-н анхан болон өдөр тутмын, давтан зааварчилгаа өгч ажиллаж байна.</p>    
<p>Гал түймрээс сэргийлэх, гал унтраах багаж хэрэгслийг байнгын бэлэн байдалд байлгах, ажиллагсдад сургалт явуулах, бусад мэдээ мэдээлэл анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг байршуулах</p>	<p>Үйлдвэрийн хашаа</p>	<p>Суурьлуулах, бэлэн байдлыг шалгах</p>	<p>Жил бүр</p>	<p>Гал унтраагуур, галын сарай хийж байршуулсан. СХД-н онцгой байдлын хэлтэсээр галын дүгнэлт гаргуулсан.</p> 
<p>Ажилчдыг эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт оруулах, Үзлэгийг ЭМН-ийн Сайдын 1999 оны А/243 тушаалын дагуу явуулах</p>	<p>Нийт ажилтан</p>	<p>100.0</p>	<p>Жил бүр</p>	<p>Шинжилгээнд хамруулсан үзлэгийн хуудас, СХД-н эрүүл мэндийн төвтэй хамтран ажилласан. Ажлын байрыг өөрийн багаж хэрэгсэлээр халдваргүйжүүлдэг болсон.</p> 

<b>Бусад /төлөвлөгөөт бус ажил/</b>				
Үйлдвэрийн харуул хамгаалалт, өнгө үзэмж			Жилдээ	<p>Үйлдвэрийн хаалга болон хашааны хаалгыг шинэчилж камерийн хяналтын системтэй болсон.</p> 
Усны бохирдол	Үйлдвэр	0	Жил бүр	<p>Хэрэглэсэн бохир усыг дахин ашиглах зорилгоор тунгаагуур нуурт тунгаагаад дахин ашигладаг.</p> 
Нийгмийн хариуцлагын хүрээнд	Компани		Жилдээ 6 удаа	<p>Нийгмийн хариуцлагын ажлын хүрээнд Улаангомоос Ховд чиглэлийн сайжруулсан шороон засмал замд 6 удаагийн засвар, түрэлт, тэгшилгээ хийсэн.</p> 

		<p>Жилдээ</p>	<p>Увс аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу Улаангомоос самбартай хөтөл чиглэлийн зам дагуу байрласан олон жил иргэд хайрга олборлон эрэг, ирмэг гаргасан байсан 1.1 га талбайтай жалгыг компанийн хөрөнгөөр 2 нэгж техник 4 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллан техникийн нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгсөн.</p> 
		<p>Сар бүр</p>	<p>Хөрс хуулалт хийхдээ шимт хөрсийг хуулан авч овоолго үүсгэн хадгалсан.</p> 
		<p>Жилдээ</p>	<p>Үйлдвэрийн хашааг тойруулан 20ш хамгаалалтын хаалт бүхий мод тарьсан</p> 

			<p>Хаврын тариалалтаар 3000ш, намрын нөхөн тариалалтаар 1000ш чяцарганын суулгацыг усалгааны систем бүхий талбайд тарьсан.</p>	 
			<p>Үйлдвэрийн байрлалд хайрганы ордын олборлолт хийгдсэн талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдэж байгаа.</p>	 

ТАЙЛАН ГАРГАСАН:  
 "ЧАНДМАНЬ УУЛЫН ХИШИГ" ХХК